



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/516

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын нутаг дэвсгэр дэх Саригийн хөндий нэртэй 25.247 гектор талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Жипэл” ХХК-д 15 жилийн хугацаатай олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Б.Дархантөр), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Татварын хэлтэс (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Д.Батхүү), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг)-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрлэлийн болон уулын ажлын үндсэн үзүүлэлтийг хуульд заасан хугацаанд багтаан батлуулах, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Жипэл” ХХК-д зөвлөсүгэй.

4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар хурандаа (Д.Батхүү), Татварын хэлтэс (А.Гантөмөр), Байгаль, орчин аялал жуулчлалын газар (Б.Дархантөр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ